

**АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА,
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХООРОНД ХАМТРАН
АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ**

2025 оны 11 сар 05 өдөр

Дугаар ...1025/07

Улаанбаатар хот

Нэг талаас Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /цаашид “Алба” гэх/ нөгөө талаас Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид “ИНЕГ” гэх/ хооронд /цаашид “Талууд” гэх/ хамтран ажиллах талаар дор дурдсан асуудлаар харилцан тохиролцож, энэхүү санамж бичгийг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийн зорилго нь Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцын хавсралт 13, Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 9 дүгээр бүлгийн дагуу агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба болон Иргэний нисэхийн ерөнхий газар /цаашид хамтад нь Талууд гэх/ -ын хоорондын хамтын үйл ажиллагаа, уялдаа холбоог зохицуулахад оршино.

1.2. Талуудын хамтын ажиллагаа нь хуулиар хориглоогүй асуудалд ил тод нээлтэй байх, хамтын ажиллагааны үр дүнг нэгтгэн хэлэлцэх, харилцан хүндэтгэлтэй хандах зарчимд тулгуурлаж үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний заалтыг удирдлага болгоно.

1.3. Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа, түүний тайлангийн дүгнэлт, аюулгүй байдлын зөвлөмж нь иргэний нисэхийн аюулгүй байдлыг бүх түвшинд сайжруулах зорилготой гэдэгт Талууд санал нэг байна.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГАА

2.1. Талуудын хамтын ажиллагаа нь Иргэний нисэхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасан зарчимд тулгуурлана.

2.2. Шинжлэн шалгах ажиллагаанд Иргэний нисэхийн тухай хууль тогтоомжид заасан болон дараах чиглэлээр хамтран ажиллана. Үүнд:

- 2.2.1. осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх зорилгод дэмжлэг үзүүлэхэд хамтран ажиллах;
- 2.2.2. мэдээ мэдээлэл, өгөгдлийн үр дүнтэй, үр өгөөжтэй солилцоог бий болгох;
- 2.2.3. мэдээлэл солилцооны нээлтэй, ил тод байдлыг хангах;
- 2.2.4. аливаа маргаан, зөрчилдөөн, ойлгомжгүй асуудлыг хоёр талын удирдлагын түвшинд хууль тогтоомжийн хүрээнд шуурхай харилцан ойлголцож шийдвэрлэх;
- 2.2.5. шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай тохиолдолд мэргэжилтэн оролцуулах асуудлыг шийдвэрлэх;

- 2.2.6. ИНЕГ нь агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой баримт, мэдээллийг саадгүй гаргаж өгөх;
- 2.2.7. агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл бусад холбогдох асуудлаар харилцан туслалцах;
- 2.2.8. агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ

3.1. Алба нь Иргэний нисэхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан агаарын хөлгийн осол, зөрчлийг Чикагогийн конвенцын 13 дугаар хавсралтын дагуу шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг гүйцэтгэх эрх бүхий байгууллага болно.

3.2. ИНЕГ нь Иргэний нисэхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д зааснаар Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын тохируулагч агентлаг байна.

ДӨРӨВ. АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭХ

4.1. Талууд агаарын хөлгийн осол, зөрчлийн талаар харилцан мэдээлэл солилцоно.

4.2. “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны дүрэм”-ийн Хавсралт В-д заагдсан мэдээлэх шаардлагатай осол, зөрчлийн талаар түрүүлж мэдсэн тал нь нөгөө талдаа аль болох шуурхай дараах хаягаар мэдэгдэнэ. Үүнд:

Алба:
Утас: 95953399
Цахим хаяг: aaib@aaib.gov.mn

ИНЕГ:
Утас: 98985525
Цахим хаяг: report@mcaa.gov.mn

ТАВ. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА

5.1. Олон улсын иргэний нисэхийн байгууллага, Конвенцын хэлэлцэн тохирогч улсуудтай хийх уулзалт, хурал, хамтын ажиллагаанд талууд Монгол Улсын ашиг сонирхлыг нэгдмэл, хамтач байдлаар илэрхийлнэ.

5.2. Талууд нь Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас ирүүлсэн Конвенцын хавсралт болон баримт бичгийн нэмэлт, өөрчлөлтийг харилцан солилцон, хамтран хэлэлцэж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлнэ.

5.3. Талууд зохион байгуулалтын, эсхүл үйл ажиллагааны байр суурь, шинэ санал санаачилгын талаар харилцан зөвлөлдөнө.

5.4. Талууд шаардлагатай тохиолдолд техник, технологийн мэдээлэл өгөх, харилцан ажиллагааны зохицуулалтын талаар холбогдох байгууллагатай уулзалт зохион байгуулна.

5.5. Агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой шинжлэн шалгах ажиллагааны дагуу гарсан аюулгүй байдлын зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийн талаар харилцан мэдээлэл болон санал солилцоно.

ЗУРГАА. ОЛОН НИЙТТЭЙ ХАРЬЦАХ

6.1. Талууд агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаатай холбоотой өөрсдийн чиг үүрэгт хамаарах мэдээллийг олон нийтэд өгч болно.

6.2. Нөгөө талын ашиг сонирхолд нөлөөлж болохуйц аливаа мэдээллийг олон нийтэд өгөхөөс өмнө харилцан зөвшилцсөн байна.

ДОЛОО. ЗАРДАЛ ШИЙДВЭРЛЭХ

7.1. Урьдчилан тохиролцсоноос бусад тохиолдолд Талуудын харилцан үйл ажиллагаа нь үнэ төлбөргүй байна.

7.2. Аль нэг талаас гаргасан хүсэлтийн дагуу Талуудын гарах зардлыг урьдчилан харилцан зөвшилцөж шийдвэрлэнэ.

НАЙМ. САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

8.1. Энэхүү Санамж бичгийн хэрэгжилтийг жилд нэг удаа дүгнэх бөгөөд шаардлагатай тохиолдолд аль нэг талын санаачилгаар хянан, хэлэлцэж болно. Үүнд:

- 8.1.1. хамтын ажиллагааны хэрэгжилт;
- 8.1.2. аюулгүй байдлын зөвлөмж болон түүний хэрэгжилт;
- 8.1.3. хяналтын явцад илэрсэн аюулгүй байдалтай холбоотой асуудлууд;
- 8.1.4. шинжилгээ судалгааны аливаа хөтөлбөр, түүний хэрэгжилт , үр дүн;
- 8.1.5. хүний хүчин зүйлийн асуудлууд;
- 8.1.6. үйл ажиллагааны бодлого болон журмууд;
- 8.1.7. агаарын хөлгийн осол, зөрчилтэй холбоотой сургалт, дадлага зохион байгуулсан байдал;
- 8.1.8. Талуудын итгэлцэл, нууцлал.

ЕС. ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

9.1. Энэхүү Санамж бичигт Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш гурван жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.


9.2. Энэхүү Санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулах эсхүл цуцлах тухайгаа аль нэг тал нь нөгөө талдаа хуанлийн 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ,
ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ
АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ШИНЖЛЭН ШАЛГАГЧ



Ж.ЦОЛМОН
8112738 ШТЖ1492 9025011078

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД
УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ



Э.ТӨРБАЯР